



Байнгын хорооны 2022 оны 15  
дугаар тогтоолын нэгдүгээр  
хавсралт

## СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж:** Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

### НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	<b>Эцэг/эхийн нэр:</b> Довдон <b>Ургийн овог:</b> Баянмарал <b>Нэр:</b> Давааням <b>Хүйс:</b> Эрэгтэй <b>Төрсөн он:</b> 1976 <b>Төрсөн газар:</b> Улаанбаатар хот, СБД, 1-р төрөх <b>Иргэний харьяалал:</b> Монгол <b>Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:</b> Улаанбаатар, Хан-Уул дүүрэг /Мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/
1.2	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</b> Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн
1.3	<b>Иргэний харьяалал</b> Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. 1.Тийм 2.Үгүй

1.4	<p><b>Боловсрол</b> Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.</p> <p>1.Дотоод хэргийн их сургуулийг хууль зүйн ухааны магистр (2010.10-2012.04) 2.Цагдаагийн академийг эрх зүйч, баклавр (1995.06-1999.06)</p>
1.5	<p><b>Эрхэлсэн ажил</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</p> <p>1.Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны 161 дүгээр тогтоол 2.Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын дарга (2024.07.09) Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Дагвадоржийн Дэлгэрсайхан Утас:99016978 3.Хууль зүй дотоод хэргийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга (2024.01.19) Хууль зүй дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийг дарга Нэргүйн Мягмар Утас:99109376 4.Гадаадын иргэн харьяатын газрын Захиргаа, удирдлагын газрын дарга (2018.12.10) Гадаадын иргэн харьяатын газрын дарга, МУ-ын гавьяат хуульч Дашдоржийн Мөрөн Утас:99118943 Гадаадын иргэн харьяатын газрын дарга Нэргүйн Ууганбаяр Утас:88117451</p>
1.6	<p><b>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал</b> Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.7	<p><b>Эрүүгийн хариуцлага</b> Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/</p> <p>Үгүй</p>
1.8	<p><b>Яллагдагчаар татагдсан эсэх</b></p>

	<p>Яллагдагчаар татагдсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол товч тайлбарыг бичих/.</p> <p>Үгүй</p>
1.9	<p><b>Сахилгын шийтгэлийн талаар</b></p> <p>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.10	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b></p> <p>-Төрийн бус байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүрэг, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичнэ.</p> <p>Үгүй</p>
1.11	<p><b>Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ</b></p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p><b>Жич:</b> Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p> <p>1.“Гадаадын иргэний виз, зөвшөөрлийн зөрчлийн хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох зарим асуудал” сэдвээр 2012 онд эрдэм дипломын зохиол бичиж, хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан бөгөөд уг бүтээл Дотоод хэргийн их сургуулийн номын санд хадгалагдаж байна.</p> <p>2.Үндэсний статистикийн хороо-ноос хэрэгжүүлж буй “Монгол Улсын иргэний бүртгэл, ердийн хөдөлгөөний статистикийн тогтолцоог</p>

	<p>бэхжүүлэх нь” төслийн нээлтийн үйл ажиллагаанд 2026 оны 04 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд оролцож, “Иргэний улсын бүртгэлийн тогтолцоо” сэдвээр илтгэл тавьсан.</p> <p>Илтгэлээр иргэний бүртгэл, ердийн хөдөлгөөний статистикийн тогтолцоонд хийгдсэн тэгш бус байдлын үнэлгээ, үйл явцын талаар танилцуулж, өгөгдлийн чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй сорилт, боломж, байгууллага хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх асуудлыг хөндөн танилцуулсан.</p> <p>3.Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн давхардал, зөрчил түүнээс үүдэн гарсан бодит кейс, улсын бүртгэл хөтлөх хүрээнд тулгагдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагыг үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт ажиллаж байнаХийайл3.</p>
--	---

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p> <p><b>“ХҮРСЭН ТҮВШИНГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛЖ, САНАЛ БҮРИЙГ ХАМГААЛЖ, СОНГОГЧДЫН ИТГЭЛИЙГ БЭХЖҮҮЛНЭ”</b></p> <p>Монгол Улс 1992 оны шинэ Үндсэн хуулиар “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгох”-оор зарлан тунхагласнаар ардчилан нийгмийн гол үнэт зүйлийн нэг болох “хуулийн засаглал, ард иргэдийн оролцоо, эрх тэгш байдал, шударга сонгууль”-ийн зарчмуудыг үндэс сууриа болгосон. Энэ үүднээс Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж хуульчилан баталгаажуулсан билээ.</p> <p>Тухайн үеэс хойш Монголын ард түмэн төрийн эрх барих байгууллагаа өөрсдийн оролцоо, сонголт, дотоод итгэл үнэмшлээр бүрдүүлж, чөлөөт сонгуулиар дамжуулан ардчиллын үнэт зүйлээ хамгаалж, хөгжүүлсээр байна. Сонгууль гэдэг нь зөвхөн саналын хайрцагт саналын хуудас хийх үйл ажиллагаа бус, харин иргэний өөрийн хүсэл зорилго, үнэт зүйл, эх орныхоо хөгжлийн талаарх байр сууриа төрд хүргэж буй хамгийн хариуцлагатай бөгөөд ухамсарт оролцоо гэж би ойлгодог. Өөрөөр хэлбэл сонгууль бол иргэн бүрийн дуу хоолой төрийн бодлого болон хэрэгжих үндсэн гүүр бөгөөд ардчиллын амин сүнс юм.</p> <p>Хэрэв миний бие Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр ажиллах боломж олдвол өнөөдрийг хүртэл бий болсон сонгуулийн тогтолцооны ололт амжилтыг хадгалан хөгжүүлж, цахим хөгжил, технологийн дэвшилд</p>
-----	---

суурилсан, иргэн төвтэй, ил тод, итгэл даасан сонгуулийн тогтолцоог улам бэхжүүлэхийн төлөө ажиллах болно.

Учир нь өнөөдөр Монгол Улс зөвхөн ардчилсан улс төдийгүй “Цахим үндэстэн” болох зорилтыг дэвшүүлэн хөгжиж байгаа энэ үед сонгуулийн байгууллагын үйл ажиллагаа ч мөн орчин үеийн технологи, мэдээллийн аюулгүй байдал, цахим засаглалын хөгжлийн чиг хандлагатай уялдан шинэ шатанд хөгжих шаардлагатай гэж үзэж байна. Энэ үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.3.1.5, 4.3.3.6 дугаар зорилтод зааснаар “Хиймэл оюун ухаанд суурилсан ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлэх, эдгээр үйл ажиллагааг автоматжуулах нь үр ашгийг нэмэгдүүлэх” зорилгоор “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хиймэл оюун ухаанд суурилсан технологийг нэвтрүүлэх”-ээр ажиллаж байна.

Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, орон нутгийн сонгуулиудыг тогтмол зохион байгуулж, сонгуулийн тогтолцоо, эрх зүйн орчин, техник технологийн шийдлээ үе шаттайгаар шинэчилсээр иржээ. Ардчиллын эхэн үед сонгуулийг уламжлалт буюу гараар санал тоолох хэлбэрээр зохион байгуулдаг байсан бол цаг хугацааны явцад улсын бүртгэлийн байгууллагын нэгдсэн мэдээллийн санд тулгуурлан сонгогчдын бүртгэл, мэдээллийн сан, санал авах ажиллагаа, дүн нэгтгэх системүүдийг үе шаттайгаар цахимжуулж эхэлсэн. Энэхүү шинэчлэлийн үр дүнд сонгуулийн үйл ажиллагаа илүү зохион байгуулалттай, нэгдсэн, шуурхай хэлбэрт шилжин хөгжих нөхцөл бүрдсэн юм.

Тэр дундаа автоматжуулсан санал тоолох системийг нэвтрүүлсэн нь Монгол Улсын сонгуулийн тогтолцоонд гарсан томоохон шинэчлэлийн нэг болсон. Энэхүү системийн ачаар саналын дүнг богино хугацаанд нэгтгэн мэдээлэх боломж бүрдэж, хүний санаатай болон санамсаргүй алдаа гарах эрсдэлийг бууруулах нөхцөл сайжирсан. Мөн сонгуулийн үйл ажиллагааны шуурхай байдал, мэдээллийн нэгдсэн зохион байгуулалт шинэ түвшинд хүрч, иргэд сонгуулийн мэдээллийг илүү хурдан, ил тод байдлаар хүлээн авах боломжтой болсоор байна.

Гэвч аливаа сонгуулийн тогтолцооны хамгийн чухал үндэс нь техник төхөөрөмж бус, харин иргэдийн итгэл юм. Технологи хөгжихийн хэрээр сонгуулийн үйл ажиллагаа илүү ойлгомжтой, нээлттэй, хүртээмжтэй байх шаардлага улам нэмэгдэж байна. Иймээс хэрэв би Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр ажиллавал сонгуулийн автоматжуулсан системийн давуу талыг хадгалан хөгжүүлэхийн зэрэгцээ иргэдийн ойлголт, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна.

Тухайлбал, санал тоолох төхөөрөмжийн ажиллагаа, мэдээлэл дамжуулах процесс, аюулгүй байдлын баталгаажуулалтын талаарх мэдээллийг иргэдэд илүү ойлгомжтой байдлаар хүргэх нь чухал гэж үзэж байна. Иргэд зөвхөн сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрөхөөс гадна тэрхүү

дүн хэрхэн гарч буй үйл явцад итгэдэг байх нь ардчиллын үнэт зүйлийг бэхжүүлэх үндэс болно.

Нөгөө талаас “Цахим үндэстэн” бодлогын хүрээнд сонгуулийн байгууллагын цахим чадавх, мэдээллийн аюулгүй байдлыг улам бэхжүүлэх шаардлагатай. Өнөөдөр дэлхий нийтэд цахим орчны эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлын асуудал нэмэгдэж байгаа энэ үед сонгуулийн системийн хамгаалалт нь зөвхөн техникийн асуудал бус, үндэсний хэмжээний итгэлийн асуудал болж байна. Иймээс хэрэв би гишүүнээр ажиллавал сонгуулийн мэдээллийн системийн аюулгүй байдлыг олон улсын стандартын түвшинд тогтмол үнэлүүлж, хараат бус мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг олон нийтэд ил тод танилцуулдаг тогтолцоог улам бэхжүүлэхийн төлөө ажиллана.

Мөн сонгогчдын оролцоог нэмэгдүүлэх асуудалд онцгой анхаарах шаардлагатай гэж боддог. Ялангуяа залуучуудын оролцоо ардчиллын ирээдүйтэй шууд холбоотой. Өнөөдрийн залуус мэдээллийг цахим орчноос авч, хурдтай өөрчлөгдөж буй нийгэмд амьдарч байгаа учраас сонгуулийн боловсролыг орчин үеийн, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх шаардлага бий. Хэрэв би Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн болбол сонгуулийн боловсролын цахим платформ, танин мэдэхүйн контент, мэдээллийн нээлттэй системийг хөгжүүлэхэд анхаарч ажиллах болно. Ингэснээр иргэн бүр сонгуулийг өөрийн эрх, оролцоо, хариуцлагатай шууд холбоотой үнэт зүйл гэж ойлгох нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Түүнчлэн ардчилсан нийгэмд хүн бүрийн оролцоо тэгш байх ёстой. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, алслагдсан бүс нутгийн сонгогчдын сонгуульд оролцох боломж, хүртээмжийг улам сайжруулах нь чухал. Сонгуулийн тогтолцоо иргэн бүрт хүрч ажиллаж байж л жинхэнэ утгаараа ардчиллын үнэт зүйл бэхжинэ гэж ойлгодог.

Нөгөө талаас Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагааны хамгийн чухал зарчим бол хараат бус, хуульд захирагдсан байдал юм. Монгол Улсын Үндсэн хуульд төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь хууль дээдлэх ёс мөн гэж заасан байдаг. Иймээс сонгуулийн байгууллага аливаа улс төрийн нөлөөллөөс ангид, зөвхөн хуульд тулгуурлан ажиллах ёстой. Хэрэв би энэ хариуцлагатай албан тушаалд сонгогдвол төвийг сахисан, ёс зүйтэй, ил тод зарчмыг чанд баримталж, иргэдийн итгэлийг хамгаалахыг өөрийн үндсэн үүрэг гэж үзнэ.

Эцэст нь хэлэхэд, сонгууль бол ардчиллын хамгийн үнэ цэнтэй илэрхийлэл бөгөөд Монгол Улсын 3,642,483 иргэний болоод сонгуулийн насны 2,390,785 сонгогч бүрийн эрх чөлөөт сонголт төрийн бодлого болон хэрэгжих үндсэн механизм юм.

Хэрэв миний бие Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр сонгогдсон тохиолдолд өнөөдрийг хүртэл бий болсон ололт, шинэчлэлийг улам төгөлдөржүүлж, санал бүрийн үнэ цэнийг хамгаалсан, иргэн төвтэй, цахим хөгжилд суурилсан, ил тод бөгөөд итгэл даасан сонгуулийн

	тогтолцоог бэхжүүлэхийн төлөө мэдлэг, ур чадвар, хариуцлагаа зориулан ажиллах болно.
--	--

**Хавсралт:**

*Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:*

- төрийн албан хаагчийн анкет;
- эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;
- тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай түвшний мэдлэг, чадвар, туршлага, ёс зүйтэй гэдгийг нотлон харуулсан 10-аас доошгүй тодорхой үйл ажиллагааны талаарх баримт;
- энэхүү загварт заасан баримт бичиг;
- холбогдох бусад баримт.

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: ДОВДОН

Өөрийн нэр: ДАВААНЯМ

Гарын үсэг: .....

Он, сар, өдөр: .....